



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2012 оны 04 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

**Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон
хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах,
хадгалах журам батлах тухай**

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.7 дахь хэсэг, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт”-ыг 2 дугаар хавсралтаар, “Нийтийн албанад томилогдооор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт”-ыг 3 дугаар хавсралтаар, “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн маягт”-ыг 4 дүгээр хавсралтаар, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ыг 5 дугаар хавсралтаар, “Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт”-ыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулж 2012 оны 02 дугаар сарын 15-ны дотор Хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлсэн албан хаагчдын “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг шинэчлэн бүртгэх ажлыг 2012 оны 8 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг 2012 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Д.ОДБАЯР

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**АЛБАН ТУШААЛТНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН
ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХЯНАХ, ХАДГАЛАХ
ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн /цаашид “мэдүүлэг гаргагч” гэх/ хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Мэдүүлэг гаргагч хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /цаашид “мэдүүлэг” гэх/-ээ хуульд заасан хугацаанд, батлагдсан маягтын дагуу үнэн зөв гаргаж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасан байгууллага, албан тушаалтанд биечлэн болон энэ журамд заасны дагуу хүргүүлнэ.

1.3. Мэдүүлэг гаргагч мэдүүлгээ бүртгүүлсний дараа түүний хөрөнгө, орлогод их хэмжээний өөрчлөлт орсон бол энэ тухайгаа Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор мэдэгдэж бүртгүүлнэ.

1.4. Мэдүүлэг гаргагч мэдүүлгээ бүртгүүлсний дараа ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон бол энэ тухай хуульд заасан байгууллага, албан тушаалтанд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

1.5. Мэдүүлэг гаргагч нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нэн даруй хүргүүлнэ.

Хоёр.Мэдүүлэг гаргах, түүнийг бүртгэх, хадгалах

2.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24.1.1, Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтад тус тус заасны дагуу дараах албан тушаалтан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт гаргаж өгнө:

- 2.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч;
- 2.1.2. Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн;
- 2.1.3. Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, дэд сайд;
- 2.1.4. Улсын ерөнхий прокурор, түүний орлогч;
- 2.1.5. Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч;
- 2.1.6. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
- 2.1.7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;
- 2.1.8. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;
- 2.1.9. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;
- 2.1.10. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн;
- 2.1.11. Үндэсний статистикийн хорооны дарга;
- 2.1.12. Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн;

- 2.1.13.Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга;
 - 2.1.14.Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн;
 - 2.1.15.Ерөнхий аудитор, түүний орлогч;
 - 2.1.16.яамны төрийн нарийн бичгийн дарга;
 - 2.1.17.Засгийн газрын агентлагийн дарга;
 - 2.1.18.Чөлөөт бүсийн захирагч;
 - 2.1.19.Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч;
 - 2.1.20.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, Ерөнхий захирал;
- 2.1.21.Засгийн газар, Ерөнхий сайдаас томилогддог бусад албан тушаалтан.

2.2.Энэ журмын 2.1-д зааснаас бусад албан тушаалтан мэдүүлгээ дараах байгууллага, албан тушаалтанд гаргаж өгнө:

2.2.1.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч Шүүхийн ерөнхий зөвлөлд;

2.2.2.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд;

2.2.3.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, ажлын албаны ажилтан, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, түүний орлогч, баг, хорооны Засаг дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд;

2.2.4.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаас томилогддог төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалтан аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт;

2.2.5.төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагч, төрийн үйлчилгээний албаны дарга, захирал, эрхлэгч, тэдгээртэй адилтгах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;

2.2.6.төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, банк, санхүүгийн байгууллага, биржийн удирдах албан тушаалтан Төрийн өмчийн хороонд /Эдгээр хуулийн этгээдийн удирдах албан тушаалд ажиллаж байгаа гадаадын иргэн нэгэн адил хамаарна/;

2.2.7.Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Төрийн өмчийн хороонд /Эдгээр хуулийн этгээдийн удирдах албан тушаалд ажиллаж байгаа гадаадын иргэн нэгэн адил хамаарна/;

2.2.8.орон нутгийн өмчит болон орон нутгийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжийн захирал тухайн шатны Засаг даргын Тамгын газарт;

2.2.9.Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусlamжийг захиран зарцуулж байгаа Засгийн газрын тусгай сангийн удирдах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд /Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу зээл, тусlamж, төсөл,

хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн зохицуулагч, удирдах албан тушаалтан нэгэн адил хамаарна/;

2.2.10.эрдэм шинжилгээ, инноваци, туршилт, зохион бүтээх ажлыг дагнан болон сургалт, үйлдвэрлэлтэй хослон гүйцэтгэдэг эрдэм шинжилгээний байгууллагын удирдах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;

2.2.11.яам, агентлагын дэргэдэх өөрийгөө санхүүжүүлдэг салбар нэгжийн удирдах албан тушаалтан харьяа байгууллагын түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;

2.2.12.Засгийн газрын тогтоолын дагуу гэрээ байгуулж төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт;

2.2.13.төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй гэрээ байгуулж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан тухайн төсвийн захирагчид /ерөнхий менежерт/;

2.2.14.төрийн улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, бие төлөөлөгч Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтан Улсын Их Хурлын Тамгын газарт;

2.2.15.Улсын Их Хурлын гишүүнээс бусад улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, ажилтан тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд.

2.3.Сонгуулийн ерөнхий хороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг, сонгуулийн тойргийн хороо Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг тус тус бүртгэж Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэн өгнө.

2.4.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон сонгогдогчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг архивын нэгж болгон тухайн сонгууль дууссанаас хойш 14 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.

2.5.Мэдүүлэг гаргагч мэдүүлгээ шуудангаар илгээх бол эрх бүхий албан тушаалтны нэр дээр “гарт нь” гэж хаяглан баталгаат шуудангаар ирүүлэх бөгөөд энэ тохиолдолд мэдүүлэг гаргасан хугацааг илгээмж дээрх шуудангийн тэмдэглэлийг үндэслэн тооцно.

2.6.Шуудангаар ирсэн мэдүүлгийг тухайн байгууллагын бичиг хэргийн асуудал хариуцсан ажилтан хүлээн авч, илгээмжийг задалгүйгээр эрх бүхий албан тушаалтанд шууд хүлээлгэн өгнө.

2.7.Мэдүүлэг гаргагч цахим шуудангаар мэдүүлгээ илгээж болох бөгөөд энэ тохиолдолд хаяг, гарын үсгийн баталгаажилт, нууцлал зэргийг мэдүүлэг хүлээн авах эрх бүхий этгээдтэй урьдчилан тохиролцсон байна.

2.8.Албан тушаалтны мэдүүлэг, мэдүүлгийн бүрдүүлэлтийг цахим хэлбэрээр явуулж болох бөгөөд цахим гарын үсгийг цахим гарын үсгийн тухай хууль тогтоомжоор хэрэгжүүлнэ.

2.9.Мэдүүлгийг цахим хэлбэрээр бүртгэхтэй холбогдсон журмыг Авлигатай тэмцэх газрын дарга Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран батална.

**Гурав.Мэдүүлгийг бүртгэж хүлээн авах байгууллага,
эрх бүхий албан тушаалтны эрх, үүрэг**

3.1.Нийтийн албаны удирдлага нь тухайн байгууллагын захиргаа, хуулийн асуудал эрхэлсэн албаны эрх бүхий албан тушаалтанд мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажлыг тушаал, шийдвэрээр хариуцуулан томилж, түүнд албан тушаалынх нь цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл урамшуулал олгох бөгөөд шаардлагатай тохиолдолд уг асуудлыг эрхлэх орон тооны ажилтантай байж болно.

3.2.Эрх бүхий албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хувь хүний нууцтай холбогдох мэдээллийг чандлан хадгалах, хамгаалах бөгөөд нууцын баталгаа гаргана.

3.3.Эрх бүхий албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасан хугацаанд мэдүүлгийг авч дууссанаас хойш 14 хоногийн дотор мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаарх тайланг, мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.

3.4.Мэдүүлгийг бүртгэж хүлээн авч байгаа эрх бүхий албан тушаалтан дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.4.1.мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй;

3.4.2.Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, Нийтийн албанд томилогоходоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хүлээн авч, бүртгэл хөтлөх бөгөөд хянан шалгах, авлигын шинжтэй зөрчил илэрвэл Авлигатай тэмцэх газарт нэн даруй шилжүүлэх;

3.4.3. Эрх бүхий албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.2 дахь заалт, 8.2, 23.3, 23.5 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 10.3, 10.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу батлагдсан маягаар бүртгэл хөтлөх;

3.4.4.энэ журмын 3.4.2-т заасан бүртгэлээс гадна Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан тохиолдолд бүртгэл, хяналт явуулж Авлигатай тэмцэх газарт мэдээлнэ.

3.5.Энэ журмын 3.4.3-т заасан бүртгэлийн маягт, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журмыг Авлигатай тэмцэх газрын дарга батална.

3.6. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг эрх бүхий албан тушаалтан хүлээн авч, холбогдох баримт бичгийн хамт Авлигатай тэмцэх газарт нэн даруй хүргүүлэх бөгөөд уг асуудлыг хариуцсан нэгж, албан тушаалтан ажлын 10 өдөрт багтаан хянаж, хариу мэдэгдэнэ.

3.7. Мэдүүлгийг бүртгэж, хадгалах эрх бүхий албан тушаалтан авлигын эсрэг хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчлийн талаар Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх Үүрэгтэй.

3.8. Албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан мэдэгдлийг дор дурдсан тохиолдолд гаргана:

3.8.1. ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсэж болзошгүй гэж үзвэл Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын түвшинд батлагдах шийдвэрийн төслийг боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох;

3.8.2. ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсэж болзошгүй гэж үзвэл Засгийн газар, Засгийн газрын гишүүн, яам, агентлаг, бүх шатны Засаг даргын түвшинд гарах шийдвэрийн төслийг боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох;

3.8.3. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах түвшинд гарах шийдвэр, гэрээ хэлцэлийн төсөл боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох.

3.10. Албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хувьцаат компанийн нийт хувьцааны 5 хүртэл хувийг эзэмшдэг, хязгаарлагдмал хариуцлагатай компаниас эзэмшиж байгаа ногдол хувь нь тухайн албан тушаалтны нэг жилийн цалингийн хэмжээнээс бага бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзнэ.

Дөрөв.Хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогыг мэдүүлэх

4.1. Мэдүүлэгт дараах зүйлийг тусгана:

- 4.1.1. мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал;
- 4.1.2. хувийн ашиг сонирхлын байдал;
- 4.1.3. хөрөнгө, орлого.

4.2. Энэ журмын 4.1.1-д заасан “Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал” гэсэн хэсэгт хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй, эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, эцэг, эхийг бичих бөгөөд үүнд гадаад улсад ажиллаж, сурч байгаа гэр бүлийн гишүүн хамаарна.

4.3. Энэ журмын 4.1.2-т заасан “Хувийн ашиг сонирхлын байдал” гэсэн хэсэгт дараах зүйлийг мэдүүлнэ:

4.3.1. “Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд” /Үүнд Нийтийн албан тушаалтны эрхлэх асуудлын хүрээ, шууд болон шууд бус нөлөөлөх боломжтой байгууллагад харьяалалтай болон хамааралтай ажил эрхэлж байгаа /байсан/ өрх тусгаарласан эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү болон эхнэр /нөхөр/, хамтран

амьдрагчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүгийн нэрийг түүний эцэг /эх/-ийн нэрийн хамт, ямар хамааралтай болох, ажиллаж байгаа /байсан/ байгууллага, албан тушаал, бизнес, үйл ажиллагааны чиглэл, төрсөн газар, үндсэн харьяаг тус тус мэдүүлнэ./;

4.3.2.“Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд” /Үүнд ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүн, хуулийн этгээд, тэдгээртэй ямар харилцаа, хамааралтай /байсан/ болох, үйл ажиллагааны чиглэл, зорилго, байгууллага, ажил, албан тушаал эрхэлж байгаа /байсан/ болон тэдгээрийн төрөл зергийг бичнэ./;

4.3.3.“Гишүүнчлэл, хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн” /Үүнд холбоо, нэгдэл, хөдөлгөөн, нутгийн зөвлөлийн тэргүүн, гишүүн, нам, улс төр, олон нийтийн байгууллагын гишүүнчлэлд байсан болон байгаа талаар бичнэ./;

4.3.4.“Төлөөлөл хэрэгжүүлсэн байдал” /Үүнд хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөн тодорхой үйл ажиллагаа, харилцаанд оролцсон талаар бичнэ./;

4.3.5.“Бэлэг, үйлчилгээ, өв залгамжпал, хандив, туслалцаа, хөнгөлөлт” /Үүнд тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас дээш хэмжээний бэлэг, үйлчилгээ, хандив, туслалцаа, хөнгөлөлтийг мэдүүлнэ./;

Тайлбар: Энэ журамд заасан “байсан” гэдэг хугацаанд Нийтийн албан д нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу сүүлийн хоёр жилийн хугацааг хамааруулж ойлгоно.

4.3.6.“Урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан байдал” /Үүнд тухайн жилд нийтийн албанд томилогодохоор нэр дэвшихдээ гаргасан урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан тухай бичнэ./;

4.3.7.Мэдүүлэг гаргагч албан тушаалын бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгтээ хамааралгүй байдлаар ашиглахгүйг мэдэгдэж гарын үсэг зурж баталгаажуулна.

4.4. Хөрөнгө, орлогыг дараах байдлаар мэдүүлнэ:

4.4.1.Орлого хэсэгт:

-“үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”;

-“шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого” /Үүнд албан байгууллага болон бусад хуулийн этгээд, хувь хүнээс олгосон шагнал, урамшуулал хамаарна./;

-“үйл ажиллагааны орлого” /Үүнд үндсэн ажлаас гадуур ажиллаж олсон орлого, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний орлого хамаарна./;

-“хөрөнгийн орлого” /Үүнд түрээс, эрхийн шимтгэл, ногдол ашиг, хүүгийн орлого, хөрөнгө бусдад ашиглуулсны орлого хамаарна./;

-“хөрөнгө борлуулсны орлого” /Үүнд хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны орлого хамаарна./;

-“хандивын орлого” /Үүнд бусдаас авсан мөнгөн хандив, тусламж хамаарна./;

-бусад орлого /Үүнд шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, бүтээгдэхүүний ашигтай загвар зохион бүтээх, спорт, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого, шагнал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, төрөөс олгож байгаа бүх төрлийн мөнгөн тэтгэмжийн орлого хамаарна/.

4.4.2. Хөрөнгө, зээл хэсэгт:

-“Орон сууц, барилга, байгууламж” /Үүнд хувийн болон нийтийн орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга, авто зогсоол, гараж, зуслангийн байр, гэр зэргийг мэдүүлнэ. “Хийц, талбай” баганад тухайн барилга байгууламжийн хийц, өрөөний тоо, талбайн хэмжээг, зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ. Гадаад улс орон, чөлөөт бүсэд байгаа орон сууц, барилга, байгууламжийг мэдүүлнэ./;

-“Тээврийн хэрэгсэл” /Үүнд автомашин, өөрөө явагч хэрэгсэл, усан онгоц, нисэх онгоц, бусад техник, тоног төхөөрөмжийг мэдүүлнэ. Зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ./;

-“Мал, аж ахуй” /Үүнд таван хошуу малаас гадна туслах аж ахуйн чиглэлээр үржүүлж байгаа гахай, тахиа, бусад тэжээвэр амьтдыг мэдүүлнэ./;

-“Газар” /Үүнд мэдүүлэг гаргагчийн болон түүний гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшлийн болон ашиглаж байгаа газрыг мэдүүлнэ./;

-“Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйл” /Үүнд хөрөнгийн нэр, үнэлгээ, эзэмшигчийн нэр, эх үүсвэрийн тайлбарыг мэдүүлнэ./;

-“Хадгаламж, бэлэн мөнгө, хувийн харилцах болон төлбөрийн данс, картны дансны үлдэгдэл” /Үүнд гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байгаа бүх төрлийн данс, картны үлдэгдлийг мэдүүлнэ. Гадаад валютыг тухайн жилийн эцсийн Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлэн дүнг бичнэ./;

-“Авлага” /Үүнд хувь хүн, хуулийн этгээдээс авах бэлэн мөнгө, хөрөнгийн дүн, хугацаа, хүү, тайлбарыг тодорхой бичнэ./;

-“Зээл” /Үүнд зөвхөн өөрийн зээлийн талаарх мэдээллийг мэдүүлэх бөгөөд бусдаас зээлсэн бэлэн мөнгө, хөрөнгийн дүн, хугацаа, зээл, зээлийн хүүгийн дүн, зориулалтыг бичнэ./;

-“Компани, нөхөрлөл, хоршоонд оруулсан хөрөнгө оруулалт” /Үүнд өөрийн болон гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулсан болон хувь нийлүүлсэн хуулийн этгээд, түүний толгой, охин, хараат болон салбар компани, аж ахуйн нэгж, гадаад, дотоодын хөрөнгийн биржээс худалдан авсан хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг мэдүүлнэ. Хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой бичнэ/;

-“Эрх, патент, тусгай зөвшөөрөл” /Үүнд өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа зохиогчийн эрх, патент, тусгай зөвшөөрлийг мэдүүлнэ./

4.5.Мэдүүлэг гаргагч мэдүүлгийг засваргүй, товч тодорхой бичих бөгөөд асуулт болгонд хариулж, байхгүй орлого, хөрөнгө, зээлийг/-/ гэсэн тэмдэглэгээ хийнэ.

4.6. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгт төрийн албан хаагчийн анкет, ял шийтгэлгүй эсэх талаарх тодорхойлолт, хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хөрөнгө, оруулагчийн талаарх лавлагаа, бусад шаардлагатай баримт бичгийг хавсаргана.

Тав. Хариуцлага

5.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ооООоо

**АЛБАН ТУШААЛТНЫ ... ОНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН
ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ**

Нэг. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал:

1.1. Мэдүүлэг гаргагч					
Ургийн овог:	Эцэг/эхийн нэр:			Нэр:	
Регистрийн дугаар:	Иргэний үнэмлэхийн дугаар:				
<input type="text"/>			<input type="text"/>		
Оршин суугаа газрын хаяг:	Гар утас: Ажлын утас: Гэрийн утас:				Цахим шуудангийн хаяг:
Боловсрол, мэргэжил:	Байгууллагын нэр:				
Төрсөн газар:	Газар, хэлтэс, тасаг, алба:				
Үндсэн харьяа:	Албан тушаал:				
Сүүлийн хоёр жил ажилласан байгууллага, албан тушаал:					
Мэдүүлэг гаргах үндэслэл: <input checked="" type="checkbox"/> тэмдэглэгээ хийнэ. Шинээр томилогдсон, Сонгогдсон <input type="checkbox"/> Шинэчлэн гаргасан <input type="checkbox"/> Их хэмжээний өөрчлөлт <input type="checkbox"/>			Тухайн албан тушаалд томилогдсон, сонгогдсон огноо: он сар ... өдөр		

1.2. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал					
Гэр бүлийн байдал	Эцэг /эх/-ийн нэр, нэр	Регистрийн дугаар	Төрсөн газар, үндсэн харьяа	Эрхэлж байгаа ажил, албан тушаал	Ажиллаж байгаа байгуулага, сурч байгаа сургууль, оршин суугаа газрын хаяг
Эхнэр, нөхөр, хамтран амьдрагч					

Хүүхэд					
Эцэг					
Эх					

Тайлбар: Хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй эхнэр, нөхөр, хамтран амьдрягч, хүүхэд, эцэг, эхийг бичнэ.

Хоёр. Хувийн ашиг сонирхол

2.1. Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд

Эцэг /эх/-ийн нэр, нэр	Ямар хамааралтай болох	Ажиллаж байгаа \байсан\ байгууллага, албан тушаал	Бизнес, үйл ажиллагааны чиглэл	Төрсөн газар, үндсэн харьяа

Тайлбар: Нийтийн албан тушаалтны эрхлэх асуудлын хүрээ, шууд болон шууд бус нөлөөлөх боломжтой байгууллагад харьяалалтай болон хамааралтай ажил эрхэлж байгаа /байсан/ өрх тусгаарласан эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, эхнэр /нөхөр/, хамтран амьдрягчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүг бичнэ.

2.2. Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд

Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Ямар харилцаатай /байсан/ болох /хуулийн этгээд бол ямар хамааралтай болох/	Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Байгууллага. ажил, албан тушаал /Эрхэлж байгаа /байсан/ үйл ажиллагааны төрөл/	Тайлбар

Тайлбар: Нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн талаар бичнэ.

2.3. Гишүүнчлэл, хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн

№	Хаана, ямар байгууллагад харьяалалтай болох	Албан тушаал, үүсгэн байгуулагч, гишүүн, дэмжигчийн аль нь болох	Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Тайлбар

Тайлбар: Холбоо, нэгдэл, хөдөлгөөн, нутгийн зөвлөлийн тэргүүн, гишүүн, нам, улс төр, олон нийтийн байгууллагын гишүүнчлэлд байсан болон байгаа талаар бичнэ.

2.4. Төлөөлөл хэрэгжүүлсэн байдал

№	Хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Төлөөллийг хаана, хэзээ, хэрхэн хэрэгжүүлсэн	Тайлбар

Тайлбар: Хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөн тодорхой үйл ажиллагаа, харилцаанд оролцсон талаар бичнэ.

2.5. Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлал, хандив, туслалцаа, хөнгөлөлт

№	Эх сурвалжийн нэр, хаяг	Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлалын төрөл	Хандив, туслалцаа, хөнгөлөлтийн зориулалт	Үнэлгээ /төгрөг/	Тайлбар
	Нийт дүн				

Тайлбар: Тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас дээш хэмжээний бэлэг, үйлчилгээ авсныг бичнэ. Хууль ёсны өв залгамжлалаар хүлээн авсан буюу авах хөрөнгийн талаар мэдүүлнэ.

2.6. Урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан байдал

№	Мэдүүлэг, мэдэгдлийн нэр	Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хэзээ, хаана, хэнд гаргасан /Байгууллага, албан тушаалтан/	Гаргах болсон шалтгаан, нөхцөл	Товч утга

Тайлбар: Тухайн жилд нийтийн албанад томилогдохоор нэр дэвшихдээ гаргасан урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан тухай бичнэ.

2.7. Албан тушаалын бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгтээ хамааралгүй байдлаар ашиглахгүйг мэдэгдье.

Гарын үсэг:

Гурав. Хөрөнгө, орлого:

3.1. Орлого /төгрөгөөр/		Орлогын дүн		Орлогын эх үүсвэр
№	Орлогын төрөл	Өөрийн	Гэр бүлийн гишүүний	
1	Үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого			
2	Шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого /албан байгууллага болон бусад хуулийн этгээд, хувь хүнээс олгосон шагнал, урамшуулал/			
3	Үйл ажиллагааны орлого /үндсэн ажлаас гадуур ажиллаж олсон орлого, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний орлого/			
4	Хөрөнгийн орлого /түрээс, эрхийн шимтгэл, ногдол ашиг, хүүгийн орлого, хөрөнгө бусдад ашиглуулсны орлого/			
5	Хөрөнгө борлуулсны орлого /Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны орлого/			
6	Хандивын орлого /бусдаас авсан мөнгөн хандив, тусламж/			
7	Бусад орлого /шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, бүтээгдэхүүний ашигтай загвар зохион бүтээх, спорт, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого, шагнал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, төрөөс олгож байгаа бүх төрлийн мөнгөн тэтгэмжийн орлого /			
8	Нийт дүн			

Тайлбар: Тайлант хугацаанд олсон орлогыг бичнэ.

3.2. Хөрөнгө, зээл

¤ Орон сууц, барилга, байгууламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

3.2.1. Орон сууц, барилга, байгууламж						
№	Орон сууц, барилга, байгууламжийн төрөл	Хийц, талбай	Байршил /хаяг/	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Бүртгэлийн гэрчилгээний дугаар	Эх үүсвэрийн тайлбар

Нийт дүн		
-----------------	--	--

Тайлбар: “Орон сууц, барилга, байгууламжийн төрөл” хэсэгт хувийн болон нийтийн орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга, авто зогсоол, гараж, зуслангийн байр, гэр зэргийг мэдүүлнэ. “Хийц, талбай” баганад тухайн барилга байгууламжийн хийц, өрөөний тоо, талбайн хэмжээ, зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ. Гадаад улс, чөлөөт бүсэд байгаа орон сууц, барилга, байгууламжийг мэдүүлнэ.

¤ Тээврийн хэрэгсэл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

3.2.2. Тээврийн хэрэгсэл					
№	Тээврийн хэрэгслийн төрөл, үйлдвэрлэсэн он	Тоо, ширхэг	Гэрчилгээ, улсын дугаар, эзэмшигчийн нэр	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Эх үүсвэрийн тайлбар
Нийт дүн					

Тайлбар: “Тээврийн хэрэгсэл” хэсэгт автомашин, өөрөө явагч хэрэгсэл, усан онгоц, нисэх онгоц, бусад техник, тоног төхөөрөмжийг мэдүүлнэ. Зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ.

¤ Мал, аж ахуй байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

4.2.3 Мал, аж ахуй					
№	Төрөл	Тоо, толгой	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Эх үүсвэрийн тайлбар	Байршил
Нийт дүн					

Тайлбар: “Мал, аж ахуй” хэсэгт таван хошуу малаас гадна туслах аж ахуйн чиглэлээр үржүүлж байгаа гахай, тахиа, бусад тэжээвэр амьтдыг мэдүүлнэ.

¤ Газар байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.4 Газар					
№	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дугаар, он, сар, өдөр	Төрөл, хэмжээ	Байршил /бүс нутаг/, хаяг	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Эх үүсвэрийн тайлбар
Нийт дүн					

Тайлбар: Мэдүүлэг гаргагчийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа болон ашиглаж байгаа газрыг мэдүүлнэ.

¤ Үнэт эдлэл, урлагийн бүтээл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.5 Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйл

№	Хөрөнгийн нэр	Үнэлгээ /төгрөг/	Эзэмшигчийн нэр	Эх үүсвэрийн болон бусад тайлбар
	Нийт дүн			

¤ Хадгаламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.6 Хадгаламж, бэлэн мөнгө, хувийн харилцах болон төлбөрийн данс, картны үлдэгдэл

№	Банк, санхүүгийн байгууллагын нэр	Дүн /төгрөг/	Эзэмшигчийн нэр	Эх үүсвэрийн тайлбар
	Нийт дүн			

Тайлбар: Энэ хэсэгт гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байгаа бүх төрлийн данс, картны үлдэгдэлийг мэдүүлнэ.

¤ Авлага байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.7 Авлага

№	Хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Дүн /төгрөг/	Хугацаа, хүү	Тайлбар
	Нийт дүн			

¤ Зээл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.8 Зээл

№	Зээлдүүлэгчийн нэр, хаяг	Анх авсан зээлийн хэмжээ /төгрөг/	Тухайн жилд зээл, зээлийн хүүд төлсөн дүн /төгрөг/	Зээл авсан, болон төлж дуусах огноо	Зориулалт	Зээлийн барьцаа, батлан даагч
	Нийт дүн					

Тайлбар: Энэ хэсэгт зөвхөн өөрийн зээлийн талаарх мэдээллийг мэдүүлнэ.

¤ Хөрөнгө оруулалт байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.9 Компани, нөхөрлөл, хоршоонд оруулсан хөрөнгө оруулалт

№	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувьцааны тоо	Нэгж хувьцааны үнэ /төгрөг/	Хувьцааг худалдаж авсан үнэ /төгрөг/	Хуулийн этгээдийн нийт дүрмийн сан /төгрөг/	Ногдол хувь	Эх үүсвэрийн тайлбар
	Нийт дүн						

Тайлбар: Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулсан болон хувь нийлүүлсэн хуулийн этгээд, түүний толгой, охин, хараат болон салбар компани, аж ахуйн нэгж, гадаад, дотоодын хөрөнгийн биржээс худалдан авсан хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг мэдүүлнэ. Хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой бичнэ

¤ Эрх, патент, тусгай зөвшөөрөл эзэмшдэгтүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.10 Эрх, патент, тусгай зөвшөөрөл

№	Төрөл	Эзэмшигчийн нэр	Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага, огноо	Тайлбар

Тайлбар: Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа зохиогчийн эрх, патент, тусгай зөвшөөрлийг мэдүүлнэ.

Мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн: / /
/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны

2012 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

**НИЙТИЙН АЛБАНД ТОМИЛОГДОХООР НЭР ДЭВШСЭН ЭТГЭЭДИЙН
ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛЭГ**

1. МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Ургийн овог:	Эцэг (эх)-ийн нэр:	Нэр:
Регистрийн дугаар:	Төрсөн он, сар, өдөр:	Иргэний үнэмлэхийн дугаар:
Төрсөн аймаг, хот: сум, дүүрэг: терсөн газар:	Оршин суугаа газрын хаяг:	
Гар утас: Гэрийн утас: Цахим шуудангийн хаяг:	Урьд нийтийн албанад ажиллаж байсан эсэх /ямар байгууллагад/: Албан тушаал:	
Сүүлийн хоёр жилийн ажил эрхлэлт:		
Нийтийн албаны аль байгууллага, албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн:		
Нэр дэвшсэн нийтийн алба /төрийн байгууллага/, түүний салбар, нэгжийн үйл ажиллагаатай хамааралтай худалдаа, үйлдвэр, үйлчилгээ эрхэлж байсан эсэх:		

2. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал

Гэр бүлийн байдал	Эцэг /эх/-ийн нэр, нэр	Регистрийн дугаар	Төрсөн газар, үндсэн захиргаа	Эрхэлж байгаа ажил, албан тушаал	Ажиллаж байгаа байгуулага, сурч байгаа сургууль, оршин суугаа хаяг
Эхнэр, нөхөр, хамтран амьдрягч					
Хүүхэд					
Эцэг					
Эх					

Тайлбар: Хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй эхнэр, нөхөр, хамтран амьдрягч, хүүхэд, эцэг, эхийг бичнэ.

3. Хувийн ашиг сонирхол

3.1. Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд				
Эцэг /эх/-ийн нэр, нэр	Ямар хамааралтай болох	Ажиллаж байгаа /байсан/ байгууллага, албан тушаал	Бизнес, үйл ажиллагааны чиглэл	Төрсөн газар, үндсэн захиргаа

Тайлбар: Нийтийн албан тушаалтны эрхлэх асуудлын хүрээ, шууд болон шууд бус нөлөөлөх боломжтой байгууллагад харьяалалтай болон хамааралтай ажил эрхэлж байгаа /байсан/ өрх тусгаарласан эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, эхнэр /нөхөр/, хамтран амьдрягчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүсийн талаар бичнэ.

3.2. Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд

Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Ямар харилцаатай /байсан/ болох /хуулийн этгээд бол ямар хамааралтай болох/	Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Байгууллага. ажил, албан тушаал /Эрхэлж байгаа /байсан/ үйл ажиллагааны төрөл/	Тайлбар

Тайлбар: Нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн талаар бичнэ.

3.3. Гишүүнчлэл, хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн

№	Хаана, ямар байгууллагад харяалтай болох	Албан тушаал, үүсгэн байгуулагч, гишүүн, дэмжигчийн аль нь болох	Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Тайлбар

Тайлбар: Холбоо, нэгдэл, хөдөлгөөн, нутгийн зөвлөлийн тэргүүн, гишүүн, нам, улс төр, олон нийтийн байгууллагын гишүүнчлэлд байсан болон байгаа талаар бичнэ.

3.4. Төлөөлөл хэрэгжүүлсэн байдал

№	Хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Төлөөллийг хаана, хэзээ, хэрхэн хэрэгжүүлсэн	Тайлбар

Тайлбар: Хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөн тодорхой үйл ажиллагаа, харилцаанд оролцсон талаар бичнэ.

3.5. Нэр дэвшилсэн нийтийн алба, байгууллагад ажилладаг, түүний эрхлэх асуудал, харьяалах нутаг дэвсгэрт байгаа хамаарал бүхий этгээд

Д/д	Эцэг /эх/-ийн нэр, нэр	Эрхэлж байгаа ажил, албан тушаал	Ямар хамааралтай болох

Тайлбар: Ямар хамааралтай болох талаар дэлгэрэнгүй тайлбарыг бичнэ.

Жич: Энэхүү маягтад төрийн албан хаагчийн анкет, ял шийтгэлгүй эсэх талаарх тодорхойлолт, хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хөрөнгө, оруулагчийн талаарх лавлагаа, бусад шаардлагатай баримт бичгийг хавсаргана.

Үнэн зөв мэдүүлсэн: /
 /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

**АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ,
ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ**

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог:	Эцэг (эх)-ийн нэр:	Нэр:
Албан тушаал:		Ажиллаж байгаа байгууллага:
Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр:		Байгууллагын хаяг:
Албан үүргийн төрөл:	Тайлбар:	

Сонирхлын зөрчилтэй эсэх

Тийм Үгүй

Хоёр.Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн

албан

тушаалтан

би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Гурав.Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:

гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:

гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:

байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:



Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал/:

нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанад нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж байна.

Дөрөв.Баталгаажуулалт.

Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

/......./
/албан тушаал/ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

... он ... сар ... өдөр

Шийдвэрлэсэн байдал

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрөх эсэх Тийм Үгүй

Хэрэв “Тийм” бол шалтгааныг тэмдэглэнэ үү.

- Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй
- Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй
- Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байхгүй

Баталгаажуулалт:

/......./
/албан тушаал/ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

... он ... сар ... өдөр

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ

1.Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан. /Эдгээр хуулийн этгээдийн удирдах албан тушаалд ажиллаж байгаа гадаадын иргэн нэгэн адил хамаарна/;

2.Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийг захиран зарцуулж байгаа Засгийн газрын тусгай сангийн удирдах албан тушаалтан. /Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу зээл, тусламж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн зохицуулагч, удирдах албан тушаалтан нэгэн адил хамаарна/;

3.Эрдэм шинжилгээ, инноваци, туршилт, зохион бүтээх ажлыг дагнан болон сургалт, үйлдвэрлэлтэй хослон гүйцэтгэдэг эрдэм шинжилгээний байгууллагын удирдах албан тушаалтан;

4.Засгийн газрын тогтоолын дагуу гэрээ байгуулж төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байга
а төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

5.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банк, санхүүгийн байгууллага, биржийн үйлчилгээний албан хаагчдаас бусад албан тушаалтан;

6.Төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй гэрээ байгуулж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

7.Улсын төсвөөс санхүүжилт авдаг болон аж ахуйн тооцоон дээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, хороо, төвийн удирдах албан тушаалтан;

8.3эвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтнээс бусад дараах албан хаагч мэдүүлэг гаргахгүй. Үүнд:

8.1.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тамирчин, арга зүйч /dasgaljuulagch/, хөгжимчин, дуучин, сантехникч, жолооч, холбоочин, сувилагч, лаборант, аптекийн эрхлэгч, эм найруулагч, тогооч, агрономич, механик, техникич, мастер, бичиг хэрэг, туслах ажилтан, нягтлан бодогч, нярав, даргын туслах, хөдөлмөрийн даамал, гал, хөдөлмөр хамгааллын байцаагч, хянагч, хөдөлмөрийн тоо бүртгэгч, сургагч ахлагч, харуулын бага дарга, асрагч, ариутгагч, шил угаагч, худалдагч, операторчин, туслах жижүүр, эрэл-тусгай бүлгийн ажилтан;

8.2.зэвсэгт хүчиний байгууллагын нярав, жолооч, дадлагын болон жолоодлогын багш, архивч, бичиг хэрэг, номын санч, туслах ажилтан, шүүх эмнэлгийн бага эмч, эмгэг судлал, номын санч, оператор, бичиг хэрэг хөтлөгч, машины оператор,

олшруулагч, хос бага мэргэжилтэн, хэрэг хөтлөгч, сахилгын хорих байрны жижүүр, ахлагчийн сургуулийн дамжааны багш, сургалт эрхэлсэн арга зүйн багш, сургагч багш, тусгай батальоны ахлагч, нууц, бичиг хэргийн эрхлэгч, туслах ажилтан, дайчилгааны хэрэг хөтлөгч, сахилгын хорих байрны жижүүр, жагсаалын дарга, экипажийн захирагч, сургагч багш, хүний нөөцийн нийгмийн хамгааллын туслах мэргэжилтэн, нөхөн хангарт, тоо бүртгэлийн туслах мэргэжилтэн;

8.3.онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тамирчин, хөгжимчин, слесарь, токарьчин, бульдозерчин, моторчин, хөрөөчин, өрөмдөгч, компрессерчин, гагнуурчин, тэсэлгээчин, дизельчин, цахилгаанчин, мастер, механик, жолооч, химич, ариутгагч, холбоочин, бичиг хэргийн эрхлэгч, гал унтраах бүлгийн дарга, туслах ажилтан, шуурхай бүлгийн аврагч, нярав, засварчин, зааварлагч, гал сөнөөгч, шүхэрчин, шугам хянагч, оператор, лаборант, шалган нэвтрүүлэгч;

8.4.цагдаагийн байгууллага, түүний харьяа спорт хороо, чуулгын тамирчин, дасгалжуулагч, дуучин, бүжигчин, хөгжимчин, аж ахуйн ажилтан, жолооч, сувилагч, шуудан хүргэгч, зарлага, хүний нөөцийн хэрэг бүртгэгч, нийгмийн ажилтан, мэдээлэл, судалгааны ахлах байцаагч /ахлах програмист/, програмист, техникич, мэдээлэл хүлээн авагч, даргын даалгавар гүйцэтгэгч, даргын туслах, бичиг хэргийн эрхлэгч, бичээч, архивч, шууданч, туслах ажилтан, сэтгэл зүйч, засварчин, нярав. Дотоодын цэргийн хөгжимчин, жолооч, бичиг хэргийн эрхлэгч, архивч, бичээч, шуурхай удирдлагын жижүүр, жижүүрийн туслах цагдаа, хүний нөөцийн хэрэг хөтлөгч, даргын туслах, нягтлан бодогч, нярав, сэтгэл зүйч, операторчин, сургалтын төвийн жагсаалын дарга, эд хариуцагч жагсаалын дарга, цэргийн гал зуухны тасгийн дарга, ашиглалтын тоо бүртгэгч, бэлтгэл хүчний салбарын ахлагч, харуулчин, довтлогч, мэргэн буудагч, механик, эрүүл ахуйч бага эмч;

8.5.хил хамгаалах байгууллагын соёл, урлаг хариуцсан албан хаагч, механик, слесарь, нохой хөтлөгч, мэргэн буудагч, өрлөгчин, зэвсгийн мастер, мужаан, жолооч, гал зуухны дарга, хилчин аврагч, тоо бүртгэгч, автогрейдерчин, засварчин, замчин, техникич, дууны найруулагч, сурвалжлагч, жагсаалын дарга, номын санч, радио станцын дарга, радио телеграфчин, тоо бүртгэгч, зохицуулагч, агрономич, бага эмч, сувилагч, мужаан, пулемётчин, кранчин, тэсэлгээчин, хилчин, харуулчин, холбоочин, гэрээт хилчин социологи, түүх, техникийн судлаач, дасгалжуулагч, тамирчин, шуурхай жижүүр, даргын туслах, сэтгэл зүйч, социологич, архивын мэргэжилтэн, мэдээлэл соёл, сурталчилгааны ажилтан, сургалтын менежер, архитектор, амралтын холбогдох албан хаагч, биеийн тамирын зааварлагч, инженер, сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга, албаны нохойн сургалтын ахлах багш, багш, засварын бүлгийн дарга, мэдээлэл, судалгааны ажилтан, сургалт, бэлэн байдлын ажилтан, малын эмч, мал зүйч, эдийн засагч, нягтлан бодогч, Хилчин хамтлагийн ахлагч, бичиг хэрэг, архивын эрхлэгч, архивч, оператор, хэвлэлийн цех, хангарт үйлчилгээний албан хаагч;

8.6.тагнуулын байгууллагын шалган нэвтрүүлэгч, харуул, бичиг хэрэг, оператор, номын сангийн эрхлэгч, харуулын ахлагч, засварчин, жолооч, бичээч, кабельчин, нярав, техникич, хэвлэгч, туслах ажилтан, нууц, бичиг хэргийн оператор. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын оператор, нярав, дэд ажилтан, харуул, шуурхай албаны жолооч, жолооч, засварчин, гагнуурчин, слесарь, зөөгч, тогооч.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт

СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИЙН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ

Нэг. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал:

1.1. Мэдүүлэг гаргагч					
Ургийн овог:	Эцэг/эхийн нэр:			Нэр:	
Регистрийн дугаар:	Иргэний үнэмлэхийн дугаар:				
Оршин суугаа газрын хаяг:	Гар утас: Ажлын утас: Гэрийн утас:			Цахим шуудангийн хаяг:	
Боловсрол, мэргэжил:	Байгууллагын нэр:				
Төрсөн газар, үндсэн харьяа:	Албан тушаал:				

1.2. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал					
Гэр бүлийн байдал	Эцэг /эх/-ийн нэр, нэр	Регистрийн дугаар	Төрсөн газар, үндсэн харьяа	Эрхэлж байгаа ажил, албан тушаал	Ажиллаж байгаа байгуулага, сурч байгаа сургууль, оршин суугаа газрын хаяг
Эхнэр, нөхөр, хамтран амьдрагч					
Хүүхэд					
Эцэг					
Эх					

Тайлбар: Хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, эцэг, эхийг бичнэ.

Хоёр. Хөрөнгө, орлого:

2.1. Орлого /төгрөгөөр/		Орлогын дүн		Орлогын эх үүсвэр
№	Орлогын төрөл	өөрийн	гэр бүлийн гишүүдийн	
1	Үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого			
2	Шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого /албан байгууллага болон бусад хуулийн этгээд, хувь хүнээс олгосон шагнал, урамшуулал/			
3	Үйл ажиллагааны орлого /үндсэн ажлаас гадуур ажиллаж олсон орлого, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний орлого/			
4	Хөрөнгийн орлого /түрээс, эрхийн шимтгэл, ногдол ашиг, хүүгийн орлого, хөрөнгө бусдад ашиглуулсны орлого/			
5	Хөрөнгө борлуулсны орлого /Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны орлого/			
6	Хандивын орлого /бусдаас авсан мөнгөн хандив, тусламж/			
7	Бусад орлого /шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, бүтээгдэхүүний ашигтай загвар зохион бүтээх, спорт, урлагийн тогтолц зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого, шагнал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, төрөөс олгож байгаа бүх төрлийн мөнгөн тэтгэмжийн орлого /			
8	Нийт дүн			

Тайлбар: Тайлант хугацаанд олсон орлогыг бичнэ.

2.2. Хөрөнгө, зээл

▫ Орон сууц, барилга, байгууламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

2.2.1. Орон сууц, барилга, байгууламж

№	Орон сууц, барилга, байгууламжийн төрөл	Хийц, талбай	Байршил /хаяг/	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Бүртгэлийн гэрчилгээний дугаар	Эх үүсвэрийн тайлбар
Нийт дүн						

Тайлбар: “Орон сууц, барилга, байгууламжийн төрөл” хэсэгт хувийн болон нийтийн орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга, авто зогсоол, гараж, зуслангийн байр , гэр зэргийг мэдүүлнэ. “Хийц, талбай” багананд тухайн барилга байгууламжийн хийц, өрөөний тоо, талбайн хэмжээг, зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ. Гадаад улс орон, чөлөөт бүсэд байгаа орон сууц, барилга, байгууламжийг мэдүүлнэ.

▫ Тээврийн хэрэгсэл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

2.2.2. Тээврийн хэрэгсэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл, үйлдвэрлэсэн он	Тоо, ширхэг	Гэрчилгээ, улсын дугаар, эзэмшигчийн нэр	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Эх үүсвэрийн тайлбар
Нийт дүн					

Тайлбар: “Тээврийн хэрэгсэл” хэсэгт автомашин, өөрөө явагч хэрэгсэл, усан онгоц, нисэх онгоц, бусад техник, тоног төхөөрөмжийг мэдүүлнэ. Зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ.

▫ Мал, аж ахуй байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

2.2.3 Мал, аж ахуй

№	Төрөл	Тоо, толгой	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Эх үүсвэрийн тайлбар	Байршил
Нийт дүн					

Тайлбар: “Мал, аж ахуй” хэсэгт таван хошуу малаас гадна туслах аж ахуйн чиглэлийн гахай, тахиа, бусад тэжээвэр амьтдыг мэдүүлнэ.

¤ Газар байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

2.2.4 Газар

№	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дугаар, он, сар, өдөр	Төрөл, хэмжээ	Байршил /бус нутаг/, хаяг	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Эх үүсвэрийн тайлбар
Нийт дүн					

Тайлбар: Мэдүүлэг гаргагчийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа болон ашиглаж байгаа газрыг мэдүүлнэ.

¤ Үнэт эдлэл, урлагийн бүтээл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

2.2.5 Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйл

№	Хөрөнгийн нэр	Үнэлгээ /төгрөг/	Эзэмшигчийн нэр	Эх үүсвэрийн болон бусад тайлбар
Нийт дүн				

¤ Хадгаламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

2.2.6 Хадгаламж, бэлэн мөнгө, хувийн харилцах болон төлбөрийн данс, картны үлдэгдэл

№	Банк, санхүүгийн байгууллагын нэр	Дүн /төгрөг/	Эзэмшигчийн нэр	Эх үүсвэрийн тайлбар
Нийт дүн				

Тайлбар: Энэ хэсэгт гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байгаа бүх төрлийн данс, картны үлдэгдэлийг мэдүүлнэ.

¤ Хөрөнгө оруулалт байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

2.2.9 Компани, нөхөрлөл, хоршоонд оруулсан хөрөнгө оруулалт

№	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувьцааны тоо	Нэгж хувьцааны үнэ /төгрөг/	Хувьцааг худалдаж авсан үнэ /төгрөг/	Хуулийн этгээдийн нийт дүрмийн сан /төгрөг/	Ногдол хувь	Эх үүсвэрийн тайлбар
	Нийт дүн						

Тайлбар: Өөрийн болон гэр булийн гишүүдийн үүсгэн байгуулсан болон хувь нийлүүлсэн хуулийн этгээд, түүний толгой, охин, хараат болон салбар компани, аж ахуйн нэгж, гадаад, дотоодын хөрөнгийн биржээс худалдан авсан хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг мэдүүлнэ. Хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой бичнэ

¤ Эрх, патент, тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

2.2.10 Эрх, патент, тусгай зөвшөөрөл

№	Төрөл	Эзэмшигчийн нэр	Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага, огноо	Тайлбар

Тайлбар: Өөрийн болон гэр булийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа зохиогчийн эрх, патент, тусгай зөвшөөрөлийг мэдүүлнэ.

¤ Зээл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

2.2.8 Зээл

№	Зээлдүүлэгчийн нэр, хаяг	Анх авсан зээлийн хэмжээ /төгрөг/	Тухайн жилд зээл, зээлийн хүүд төлсөн дүн /төгрөг/	Зээл авсан, болон төлж дуусах он, сар, өдөр	Зориулалт	Зээлийн барьцаа, батлан даагч
	Нийт дүн					

¤ Авлага байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

2.2.7 Авлага

№	Хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Дүн /төгрөг/	Хугацаа, хүү	Тайлбар
	Нийт дүн			

¤ Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлал, хандив, туслалцаа, хөнгөлөлт байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

2.5. Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлал, хандив, туслалцаа, хөнгөлөлт

№	Эх сурвалжийн нэр, хаяг	Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлалын төрөл	Хандив, туслалцаа, хөнгөлөлтийн зориулалт	Үнэлгээ /төгрөг/	Тайлбар
	Нийт дүн				

Тайлбар: Тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас дээш хэмжээний бэлэг, үйлчилгээ авсныг бичнэ. Хууль ёсны өв залгамжлалаар хүлээн авсан буюу авах хөрөнгийн талаар мэдүүлнэ.

Мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн: / /
/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

... оны ... дугаар сарын ...-ны өдөр